



**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ 2024 ОНЫ 1  
ДҮГЭЭР УЛИРЛЫН ТОЙМ**

## МХБ-ээр арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний 2024 оны 1 дүгээр улирлын арилжааны тойм

2024 оны 1 дүгээр улиралд нийт 197 удаагийн УУБ-ийн цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсан байна. “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан “Эрдэнэс таван толгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Хангад эксплорэйшн” ХХК нь 5.22 сая тонн нүүрсийг 2.39 их наяд төгрөгөөр, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь нийт 358.8 мянган тонн төмрийн хүдэр болон баяжмалыг 94.94 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

### Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа

2024 оны 1 дүгээр улиралд нийт 127 удаагийн арилжаа амжилттай явагдаж 5.58 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжигдсан бөгөөд нүүрсний арилжаагаар 5,222,400 тонн нүүрс, төмрийн арилжаагаар 358,800 тонн төмрийн хүдэр болон баяжмал тус тус арилжигдсан байна. Нийт арилжааны 93.57 хувийг нүүрсний арилжаа, 6.43 хувийг төмрийн баяжмалын арилжаа тус тус эзэлж байна.

График 1. 2024 оны 1 дүгээр улирлын уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа.



### 1. Нүүрсний арилжаа


2024 оны 1 дүгээр улиралд нийт 68 удаагийн нүүрсний дуудлага арилжаа явагдаж 5.22 сая тонн нүүрсийг 2 их наяд 393.14 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан нүүрсний үнийн өсөлтийн дундаж 11.48 хувь байна. 2024 оны 1 дүгээр улиралд худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан нүүрсний үнийн өсөлтөөс нийт 301.72 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна. Тайлант хугацаанд 1 удаагийн нүүрсний арилжаагаар дунджаар 76.8 мянган тонн нүүрсийг 35.19 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Хүснэгт 1. 2024 оны 1 дүгээр улиралд арилжигдсан нүүрсний хэмжээ, үнийн дүн.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ /тонн/	Үнийн дүн /төгрөг/
1	Баяжуулсан коксжих нүүрс	768,000	496,537,475,200
2	Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс	1,260,800	699,288,738,637
3	Баяжуулсан сул коксжих нүүрс	12,800	6,668,147,200
4	1/3 коксжих нүүрс	2,796,800	1,090,388,849,338
5	Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс	128,000	33,765,465,600
6	Эрчим хүчний нүүрс	128,000	23,332,335,488
7	Дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрс	128,000	43,157,997,824
<b>Нийт</b>		<b>5,222,400</b>	<b>2,393,139,009,286</b>


Нийт нүүрсний арилжааны үнийн дүнгийн 45.56 хувь буюу 1 их наяд 90.39 тэрбум төгрөгийг 1/3 коксжих нүүрсний арилжаа, 29.22 хувь буюу 699.29 тэрбум төгрөгийг Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрсний арилжаа, 20.75 хувь буюу 496.54 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих нүүрсний арилжаа, 0.97 хувь буюу 23.33 тэрбум төгрөгийг Эрчим хүчний нүүрсний арилжаа, 0.28 хувь буюу 6.67 тэрбум төгрөгийг Баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа, 1.41 хувь буюу 33.77 тэрбум төгрөгийг Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрсний арилжаа, 1.8 хувь буюу 43.16 тэрбум төгрөгийг Дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрсний арилжаа тус тус эзэлж байна.

График2. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /бүтээгдэхүүний төрлөөр/.



Нүүрсний арилжааны нийт үнийн дүнгийн 77.56 хувь буюу 1 их наяд 856.17 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс таван толгой” ХК, 22.16 хувь буюу 530.3 тэрбум төгрөгийн арилжааг “Энержи ресурс” ХК, 0.28 хувь буюу 6.67 тэрбум төгрөгийн арилжааг “Хангад Эксплорэйшн” ХХК тус тус эзэлж байна.

График3. Нийт нүүрсний арилжааны үнийн дүнд эзлэх хувь /худалдагч компаниуд/.



2024 оны 1 дүгээр улиралд нийт 68 нүүрсний арилжаа амжилттай явагдсан бөгөөд 2 дугаар сард хамгийн их буюу 24 удаагийн нүүрсний арилжаа хийгдсэн байна. Үүнд:

- 1 дүгээр сард нийт 22 удаагийн нүүрсний арилжаа явагдаж 1,504,000 тонн буюу 626.53 тэрбум төгрөгийн арилжаа,
- 2 дугаар сард нийт 24 удаагийн нүүрсний арилжаа явагдаж 2,438,400 тонн буюу 1 их наяд 231.56 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард нийт 22 удаагийн нүүрсний арилжаа явагдаж 1,280,000 тонн буюу 535.04 тэрбум төгрөгийн арилжаа тус тус явагдсан.

## 2. Төмрийн хүдэр, баяжмалын арилжаа

2024 оны 1 дүгээр улиралд нийт 59 удаагийн арилжаагаар 358.8 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 94.94 тэрбум төгрөгөөр арилжсан.


Үүнд:

171,450 тонн буюу 51.59 тэрбум төгрөгийн төмрийн баяжмал, 187,350 тонн буюу 43.35 тэрбум төгрөгийн төмрийн хүдэр тус тус арилжигдсан байна. Тодруулбал: Fe – 65%-ийн төмрийн баяжмал 99,000 тонн буюу 33.32 тэрбум төгрөгийн, Fe – 58%-ийн төмрийн баяжмал 72,450 тонн буюу 18.27 тэрбум төгрөгийн, Fe-52%-ийн төмрийн хүдэр 187,350 тонн буюу 43.35 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийсэн байна. Үүнд:

- 1 дүгээр сард 16 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 102,000 тонн буюу 30.11 тэрбум төгрөгийн арилжаа,
- 2 дугаар сард 32 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 200,700 тонн буюу 50.2 тэрбум төгрөгийн арилжаа,
- 3 дугаар сард 11 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 56,100 тонн буюу 14.64 тэрбум төгрөгийн арилжаа,

Дуудлага худалдаагаар арилжсан төмрийн хүдэр болон баяжмалын үнийн өсөлтийн дундаж 2.63 хувь байна. Төмрийн баяжмал, хүдрийн арилжааны нийт үнийн дүнгийн 62.98 хувь буюу 59.79 тэрбум төгрөгийн арилжааг “Монголросцветмет”ТӨҮГ, 37.02 хувь буюу 35.15 тэрбум төгрөгийн арилжааг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК тус тус эзэлж байна. 2024 оны 1 дүгээр улиралд худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан төмрийн баяжмал, хүдрийн үнийн өсөлтөөс нийт 1.66 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

График4. 2024 оны 1 дүгээр улиралд арилжигдсан төмрийн хүдэр, баяжмал



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
УУБ-НИЙ АРИЛЖАА БҮРТГЭЛИЙН ГАЗАР